

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ПАКТЫН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛТЭЙ ҮНДЭСНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХУУЛЬ ТОГТООМЖ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ТЭДГЭЭР ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ¹

УДИРТГАЛ

Засгийн газраас 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г баталсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 8 дахь хэсгийн 39-д Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйл, уг зүйлийн холбогдох тайлбартай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохицуулсан үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэхэд судалгаа хийхээр төлөвлөсөн.

Уг арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу /цаашид “аргачлал” гэх/ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний зорилго нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай зохицуулсан холбогдох хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл, уг зүйлийн холбогдох тайлбартай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохицуулсан үндэсний хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж нийцэж байгаа эсэхийг аргачлалын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Төлөвлөх үе шат нь дараах дараалалтай байна. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүний нэмэлт протокол (1966)²-аас гадна Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1945)³, Хүний эрхийн тухай Европын конвенц (1950)⁴, Америк дундын хүний эрхийн конвенц (1969)⁵ зэрэг Олон улсын конвенцоор баталгаажуулж ирсэн.

Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн (цаашид “Үндсэн хууль” гэх) Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.”, 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв

¹ Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

² Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 19 дүгээр зүйл.

³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 19 дүгээр зүйл.

⁴ Хүний эрхийн тухай Европын конвенц, 10 дугаар зүйл.

⁵ Америк дундын хүний эрхийн конвенц, 13 дугаар зүйл.

журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;⁶ хэмээн тус тус заасан.

Үзэл бодлыг чөлөөт байдлаар бий болгох явдал нь харилцааны үйл явцад хэрэгждэг. Үүний тулд нэг талаас үзэл бодлоо илэрхийлж түгээх эрх чөлөө, нөгөө талаас илэрхийлсэн үзэл бодлыг хүлээж авах буюу мэдээлэл авах эрх чөлөө байх шаардлагатай.⁷ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 болон 17 дугаар заалтуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийг хүлээж авч өөрийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрхийг хүний үндсэн эрхийн хэмжээнд баталгаажуулж байгаагийн зэрэгцээ мөн харилцааны үйл явцыг Үндсэн хуулиар хамгаалах зорилгыг тавьж байгаа юм. Уг зорилгыг хэрэгжүүлэх чухал үйл явц нь Үндсэн хуульд нийцсэн хуулиудыг Хууль тогтоогчийн зүгээс баталж мөрдүүлэх явдал юм.

ХЭҮК-оос 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 623-н гомдол хүлээн авч шийдвэрлэснээс 6 нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой гомдол байна.⁸ Дээрх тоон үзүүлэлтийг харвал Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчил харьцангуй бага мэт харагдаж байгаа хэдий ч Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагаас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2016 онд 180 орноос 60 дугаар байр, 2017 онд 69 дүгээр байр, 2018 онд 71 дүгээр байранд тус тус орж сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол доошилсоор байна.⁹ Үүнээс үзвэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд анхаарч сайжруулах асуудал байсаар байна.

Иймд энэхүү үнэлгээгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй 685¹⁰ хуулиас шууд холбоотой 38 хууль /хавсралт 3-ийг үзэх/ байгаагаас Монгол Улсын Үндсэн хуулинд заасан “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” эрхийг хуулийн зорилтоос эхлэн хангахад чиглэсэн байдлыг харгалзан үзэж сонгосон болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.¹¹ Иймд үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хангах хоёр хуулинд хэрэгжилтийн үр дагаврыг тооцох юм. Дээрх судалгааны хүрээнд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалтыг сонгон авч, тэдгээрийн эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхээр судалгааны хүрээг тогтоов.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

⁶ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он.

⁷ Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь” Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 106 дахь тал.

⁸ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. <http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/>

⁹ World Press Freedom Index, accessed April 1, 2019, <https://rsf.org/en/ranking/2018>

¹⁰ <https://www.legalinfo.mn/> сүүлд үзсэн 2019.04.22.

¹¹ ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал.

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;” 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;” хэмээн тус тус заасан бөгөөд Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс УИХ-аас хууль тогтоомжид тусгасан зүйл, заалт олон байх боловч шууд хангахад чиглэсэн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай”, “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хуулийг батлан мөрдүүлж байна. Тухайлбал; Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.” хэмээн заажээ. Үүнээс үзвэл, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үндсэн зорилт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангаж, баталгаажуулах Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний эрхийг хангахад чиглэсэн болох нь харагдаж байна. Иймд, энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилтыг хангахтай холбогдуулан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.” 3 дугаар зүйлийн 1-д “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.” 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэж заасан зохицуулалтыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	2 дугаар зүйл	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.
2.	3 дугаар зүйл	3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.
3.	4 дүгээр зүйл	Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” хэмээн заасан байна.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг иргэд дийлэнх тохиолдолд төрийн байгууллагын тодорхой шийдвэрийг эсэргүүцэн хэрэгжүүлдэг. Гэтэл уг шийдвэрийг эсэргүүцэн иргэд үзэл бодлоо илэрхийлэн жагсаал, цуглаан хийхдээ тухайн шийдвэрийг гаргадаг байгууллагад

мэдэгдэн бүртгүүлдэг. Хэрэв жагсаал, цуглаан хийх талаар бүртгүүлээгүй тохиолдолд зөвшөөрөлгүй хэмээн албадан тараах үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь практикт ихээхэн маргаан дагуулдаг байна.

Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	9 дүгээр зүйлийн 9.1	Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.
2.	14 дүгээр зүйлийн 14.1	<p>1. Дараахь тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана:</p> <p>1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол;</p> <p>2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;</p> <p>3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол;</p> <p>4/ жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол;</p> <p>5/ жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3,12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.</p>

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;
- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл зорилгодоо хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа эсэх?

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл уншиж, судлах, харьцуулалт хийх зэрэг аргуудыг ашигласан бөгөөд ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоос холбогдох хууль, хэм хэмжээний актыг судлах, холбогдох ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаанд тулгуурлав.

Баримт бичгийн судалгаа: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбогдох Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, 1992 он.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №10, 1998 он.
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №9, 1994 он.
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №8, 2005 он
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №26, 2011 он.
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №5, 2002 он.
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7, 2016 он.
- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №36, 2016 он.
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №2, 1994 он.
- Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №9, 2016 он.
- Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №24, 2017 он.
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоол.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай, УИХ-н 2004 оны 26 дугаар тогтоол.

- “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол;

Олон улсын хэм хэмжээ

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1945 он.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт түүний нэмэлт протокол, 1945 он.
- Хүний эрхийн хорооны үйл ажиллагааны түр журам, 1978 он.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ, 1953 он.

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл II боть, 2010-2011 он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь” Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Глоб Интернейшнл ТББ, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Сэтгүүлч ба хууль, №3, 2001 он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Хүний эрхийн цуврал нийтлэл”, 2012 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он.
- О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, №2, 2017 он.
- О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1, 2018 он.
- Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, №3, 2004 он.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал, цуглаан хийх эрхийн тухай хуулийн хүрээнд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.” хэмээн заасан. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл нь зорилтод хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.

3 дугаар зүйл. Мэдээлэлд хяналт тавихыг хориглох

3.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.

Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

Үнэлгээ:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд тусгасан зохицуулалтаас үзвэл тус хуулийн зорилт нь Үндсэн хууль болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үндсэн зорилгыг хангахад чиглэсэн болох нь харагдаж байна.

Итгэл үнэмшилтэй байж Үзэл бодлоо илэрхийлэх нь хүний сэтгэл зүй, улс төр, ёс зүйн болон бусад шинжийг илэрхийлсэн процесс юм.¹² Энэ эрх чөлөө нь хүний мөн чанар, оршин байгаатай нь холбогдон гарч ирдэг, төрөөс тогтоодоггүй түүнээс ангид оршдог, хүний төрөлх буюу оюун санааны эрх гэж ойлгож болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө нь маш эмзэг, байнга хөндөгдөж байдаг бөгөөд түүнийг маш зөв, соёлтой хэрэглэх, хамгаалах учиртай.¹³ Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь:

- Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар (үг хэлэх);
- Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх);
- Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Эрж хайх (мэдээлэл авах);
- Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах);
- Түгээх;
- Тайван жагсаал, цуглаан хийх;
- Эвлэлдэн нэгдэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;
- Ажил хаях;
- Өлсгөлөн зарлах зэрэг багц эрх¹⁴ эрх чөлөөний эх сурвалж, анхдагч суурь эрх юм.

Иргэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд төр, нийгэм, орон нутгийн асуудлыг шийдэх үйл хэрэгт дараах байдлаар оролцож болно. Тухайлбал;

- Оршин буй газрынхаа баг, хорооны иргэдийн нийтийн хурал, олон нийтийн цуглаанд оролцох;
- УИХ-ын гишүүнээр дамжуулан оролцох;
- Олон нийтийн санал асуулга явуулахад оролцох;
- Хуулийн хэлэлцүүлэг, санал шүүмжлэлд оролцох;
- Төрийн бус байгууллагаар дамжуулан оролцох;
- Сонин, хэвлэл, телевизээр үзэл бодлоо илэрхийлэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд захидал бичих;
- Жагсаал цуглаанд оролцох;
- Өөрсдийн саналаа өргөн барих;
- Олон нийтэд хандаж үг хэлэх¹⁵ зэргээр бодлого боловсруулах бүх шатны үйл ажиллагаанд оролцож болно.

Гэвч үзэл бодлоо илэрхийлэх эрх нь дээр дурдсан эрхээр хязгаарлагдахгүй, учир нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2-д хүн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заасан байна. Үүнээс

¹² Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.

¹³ Глоб Интернетейшнл ТББ, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Сэтгүүлч ба хууль, 2001 он, №3, 23 дахь тал.

¹⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

¹⁵ Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Хүний эрхийн цуврал нийтлэл”, 2012 он, 54 дэх тал.

үзвэл “хэвлэл мэдээллийн эрх чөлөө” нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийн дээр заасан аргуудаас “Сонин, хэвлэл, телевизээр үзэл бодлоо илэрхийлэх” гэсэн зөвхөн нэг л үндсэн арга болох юм.

Мэдээллийн эрх чөлөө гэдгийг мэдээлэл ил тод, нээлттэй байх, хүн бүр мэдээллийг чөлөөтэй олж хүртэх боломж, баталгаа хангагдсан байхыг ойлгодог. Хүн бүр мэдээллийн эрх чөлөөг эдлэх эрхтэй. Энэхүү эрх чөлөөг эдлэхэд тодорхой арга, хэрэгсэл хэрэгтэй. Эдгээр арга, хэрэгсэл нь хүний эрх гэсэн категориор тодорхойлогдож байдаг. Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субъектын тодорхой үйлдэл, үйл ажиллагаагаар дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.¹⁶ Үүнд:

- Нэг дэх шат: Мэдээлэл хайх эрх /freedom to seek/
- Хоёр дахь шат: Мэдээлэл олж авах /freedom to receive/
- Гурав дахь шат: Мэдээлэл тараах, түгээх /freedom to impart information/

Мэдээллийг хайх, олж авах, түгээх үе шат нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой үйл явц бөгөөд энэхүү үйл явц, үе шатыг дамжиж мэдээлэл олон нийтэд хүрч нийтийн хүртээл болдог. Мэдээлэл хайх, олж авах, түгээх үйл явцыг хүний үндсэн эрхийн үүднээс олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний үндсэн эрх болохыг хуульчлан тогтоожээ. Эдгээр нь мэдээллийн эрх чөлөөг эдлэх гол арга хэрэгсэл болдог.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах үүднээс УИХ-аас 1998 онд баталсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн 2 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг, 3 дугаар зүйлд төрөөс олон нийтийн мэдээллийн агуулагад хяналт /цензур/ тавихыг, 4 дүгээр зүйлд төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг тус тус хориглож хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийн төлөө хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай шууд холбогдох эрх зүйн актуудыг судалж үзэхэд хууль 44 /хавсралт 1-ийг үзэх/, Олон улсын гэрээ 4 , УИХ-ын тогтоол 6, Улсын дээд шүүхийн тайлбар 14 байлаа. Эдгээр актыг судлах явцад зарим алдаа дутагдалтай хийгдэх ёстой ажиллагаа хийгдээгүй үр дүн нь гараагүй байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, 2005 онд баталсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар төрийн мэдэлд байсан үндэсний хэмжээний радио, телевизийг “олон нийтийн” болгон өөрчилж, 2011 онд баталсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулиар төрийн байгууллагаас олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулсан.

Мөн 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гүтгэх, доромжлох асуудлыг тус хуулиар бус, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр болсон гэх мэт хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх эерэг эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч цаашид анхаарах асуудал байсаар байна.

Монгол Улсад олон жил Эрүүгийн хуулиар гүтгэлэг, доромжлолыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэж ирсэн байдаг. 2015 оны шинэчилсэн найруулсан Эрүүгийн хуулиас халсан нь үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалахад чухал нөлөөлсөн хэдий ч 2017 оны Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлд “1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” хэмээн хуульчилж өгсөн бөгөөд ажил хэргийн нэр хүнд гэх ойлголтыг оруулж өгсөн нь зөрчлийн хүрээг өргөжүүлсэн зохицуулалт болсон.

¹⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

Ингэснээр албан тушаалтнууд гүтгэх, доромжлох гэмт хэрэгтэй адилхан гүтгэх зөрчлийг өөрсдийн эсрэг эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө шүүмжийг хааж бооход ашиглах эрсдэл хэвээр байна. Мөн Зөрчлийн хуулиар гүтгэсэн гэж их хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэх боломж нь үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхэд айдас төрүүлдэг. Их хэмжээний торгууль төлөх айдас нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хэвлэх, мэдээлэхээс хэвлэлийнхэн татгалзахад хүргэнэ.¹⁷ гэж үздэг байна.

УИХ-аас 2003 оны 41 дүгээр тогтоолоор Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрт “Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг, хариуцлага иргэдээс мэдээлэл олж авах түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлнэ”, “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орон нутгийн өмчид байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт эрх зүйн арга хэмжээг авна”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно”, “Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчдийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсэн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна” зэрэг ажлыг гүйцэтгэхээр тусгасан боловч дээрх ажлын хүрээнд хийгдэх зарим арга хэмжээнүүд төдийлөн хэрэгжээгүй байгаа нь энэ талаарх хийгдсэн судалгаа болон тайлан мэдээнүүдээс харагдаж байна.¹⁸

УИХ-аас 2004 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоор “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан боловсруулж шийдвэрлэнэ” гэж заасан ч хэрэгжээгүй байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь өөрөө тунхгийн шинжтэй учир хуулийн зүйл заалтууд нь өөр бусад хуультай зөрчилдсэн гэж үзэж болохоор 5 хууль байна. Үүнд:

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.”, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Хот сонин, радио, телевизтэй байж болно” гэж тус тус заасан байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэсэн заалттай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагад харьяалагдах хэвлэл мэдээллийн байгууллага байх ёсгүй юм.

Мөн 2005 онд батлагдсан Олон нийтийн, радио телевизийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-д “Олон нийтийн радио, телевиз хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана.” гэж заасан нь мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчдийн эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хаасан зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

¹⁷ О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, 2017 он, №2, 25 дахь тал

¹⁸ Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин судалгаа, <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-context/translation-law/>

Түүнчлэн 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-д “Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” хэмээн заасан бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь бусад хууль тогтоомж хэм, хэмжээний акттай хэрхэн нийцэж байгаа эсэх?

9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журам

1. Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах

1. Дараах тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана:

1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол;

2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;

3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол;

4/ жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол;

5/ жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3,12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.

Үнэлгээ:

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь дараах хэм хэмжээгээр баталгаажсан байдаг.

Үүнд:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.”, 20 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.” хэмээн тус тус заасан байна.

Өөрөөр хэлбэл, тус тунхаглалын 19 дүгээр зүйлд тусгасан зохицуулалт нь нэгдүгээрт хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй, хоёрдугаарт хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтах бол 20 дугаар зүйлд тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй хэмээн олон улсын хэмжээнд баталгаажуулсан бол Үндэсний хэмжээнд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх,

тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.” хэмээн хуульчилан баталгаажуулсан байна.

Дээр дурдсанчлан¹⁹ жагсаал цуглаан хийх эрх чөлөө нь Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн аргын нэг юм. Учир нь улс төр, нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд иргэн ганцаараа үзэл бодлоо илэрхийлбэл тийм ч үр дүнтэй биш бөгөөд хамтаараа цуглаад үзэл бодлоо илэрхийлбэл үр дүнд хүрэх магадлал нь нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, жагсаал, цуглаан нь хүмүүст дуу хоолойгоо хүчтэй илэрхийлэх боломж олгодог, олон нийтийн анхаарлыг илүү татдаг төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслийг ч татан оруулж чаддагаараа аливаа шийдвэр гаргалтад илүү нөлөөлөл үзүүлдэг гэж хэлж болно.

Цуглаан нь мөн улс төрийн намын гол үйл ажиллагааны нэг бөгөөд хүмүүсийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэхийг зөвшөөрөхгүйгээр ардчилсан сонгууль явагдах боломжгүй. Мөн, цуглааны үеэр хүмүүс өөрсдийн итгэл үнэмшил, шашин шүтлэг үзэл бодлыг илэрхийлдэг учраас энэ эрх чөлөө нь итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хамт хэрэгждэг.²⁰ Энэ ч үүднээс үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөө болон тайван, жагсаал цуглаан хийх эрх нь нэг нь нөгөөгүйгээр хэрэгжих боломжгүй хоорондоо нягт уялдаа холбоотой байдгаараа онцлог юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гол арга болох тайван жагсаал, хийх эрхийг дотор нь:

1. Тайван жагсаал, цуглааныг санаачлах эрх;
2. Тайван жагсаал цуглааныг зохион байгуулах эрх;
3. Тайван жагсаал цуглаанд оролцох эрх гэж гурав ангилан авч үзэж болдог байна.²¹

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хангах үүднээс УИХ-аас 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хуулийг баталсан. Уг хууль нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний үндсэн эрх хэрэгжих чухал баримт бичгийн нэг болсон бөгөөд анх батлагдахдаа жагсаал, цуглаан зохион байгуулахдаа Засаг даргаас “зөвшөөрөл” авдаг байсан бол 2005 онд энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж “зөвшөөрөл” гэдэг үгийг өөрчилж “мэдэгдэл” болгосон. Мэдэгдлийг бүртгүүлсний үндсэн дээр жагсаал, цуглаан зохион байгуулах нь үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах, нийгмийн дэг журмыг алдагдуулах, хүн амын эрүүл мэндийг хохироох, бусдын эрх чөлөөнд халдах аюултай байдлаас сэргийлэх зорилготой хэдий ч дээрх зохицуулалт нь зайлшгүй шаардлагатай тохирсон эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал: Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” хэмээн заасан бөгөөд Засаг дарга мэдэгдлийг хүлээж авсан эсэхээ ажлын 3-н өдрийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэйгээр зохицуулсан.

Мэдэгдэлийн тогтолцоо нь нэг талаас Засаг даргад мэдэгдсэн тэр өдрөө л жагсаал, цуглаан хийж болдог. Нөгөө талаас жагсах, цуглах эрхээ эдэлж байгаа хүмүүс рүү бусад иргэд болоод байгууллагаас халдаж, саад учруулахаас сэргийлэх. Мөн жагсаж, цуглаж буй иргэд эмх замбараагүй байдал бий болгож бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулах юм бол таслан зогсоход бэлэн байна. Ийм учраас мэдэгдэх ёстой байдаг. Үүнийг мэдэгдлийн тогтолцоо гэх бөгөөд Энэ нь өөрөө нийгмийн дэг журам, үндэсний аюулгүй байдал зэрэг ашиг сонирхлуудыг зайлшгүй хамгаалахад зориулагдсан тогтолцоо юм.²²

¹⁹ Энэ талаар судалгааны 5 дахь талд дурдаж өгсөн.

²⁰ О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №1, 15 дахь тал.

²¹ Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, 2004 он, №3, 41 дахь тал.

²² О.Мөнхсайхан, Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг Засаг даргын үзэмжээр хааж, боож байна, /Ярилцлага/, <https://ikon.mn/n/z1y/cyuld/uzsen/2019.04.19>

Гэтэл дээрх хуулийн заалт дахь мэдэгдлийг бүртгэх үүрэг бүхий субъект болох Засаг даргыг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д төрийн улс төрийн албан хаагч байна гэж хуульчилсан. Иймд тодорхой нэг улс төрийн үзэл суртал зэргээс үүдэн Засаг дарга жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхгүй байх удаашрах зэрэг нөхцөл байдал үүсэх боломжтой харагдаж байна.

Энэ талаар жишээ дурдвал, Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нэхэмжлэгч Д.Ариун-Адъяа, Я.Мөнхбат, Ц.Ууган, Д.Хатансэлэнгэ нарийн нэхэмжлэлтэй Сонгино хайрхан дүүргийн Засаг даргад холбогдох хэргийг хянан хэлэлцэж 406 дугаартай шийдвэр гаргасан бөгөөд дээрх шийдвэрийн агуулга нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын жагсаал, цуглааныг бүртгэхгүй байгаа эс үйлдэхгүйг хууль бус хэмээн бүртгэхийг даалган шийдвэрлэсэн байна.²³

Үүнээс гадна практикт Засаг дарга хуульд заагаагүй үндэслэлээр мэдэгдлийг бүртгэхээс татгалзах тохиолдол гардаг байна. Жишээ нь: 2006 онд “Эрүүл нийгэм” иргэний хөдөлгөөнөөс жагсаал, цуглаан хийх мэдэгдэл өгөхөд Засаг дарга “Өөр үйл ажиллагаатай давхацсан, автомашины хөдөлгөөнд саад учруулна, иргэдийг бухимдуулна” гэсэн шалтгаан хэлж, татгалзсан байна.²⁴

Иймд дээрх хуулийн зохицуулалтаас үүдэн иргэний үзэл бодлыг Засаг дарга хянаж жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэх эсхүл бүртгэхгүй байх эрх зүйн орчин бүрдсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд заасан эрхийг хангахад үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж байгааг судлан дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

Олон улсын гэрээ болон Үндсэн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх үүднээс УИХ-аас хууль тогтоомжид тусгасан зүйл, заалт байх боловч шууд хангахад чиглэсэн нь “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай”, “Жагсаал цуглаан хийх журмын тухай” хууль байна. Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хангах үндэсний хууль тогтоомжийн гол төлөөлөл болох дээрх хоёр хуулийн хэрэгжилтэд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдлыг тодорхойлон үзлээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд заасан эрхийг хангах болон Үндсэн хуулиар заасан зорилгыг хангахад Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн зорилт хангасан байх боловч хуулиудын зүйл заалт, бусад хуультай нийцэхгүй, хууль хэрэгжихгүй байх тохиолдол үүссээр байна. Тухайлбал: УИХ-аас 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон”. Мөн 3 дугаар зүйлд “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4 дүгээр зүйлд “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэж заасан. Гэсэн хэдий ч орон нутгийн засаг, захиргаа, хот, өөрийн харьяаны мэдээллийн хэрэгсэлтэй байна. Мөн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй холбоотойгоор сэтгүүлчид эх сурвалжаа нууцлах эрхгүй болсон.

Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд

²³ http://new.shuukh.mn/zahirgaanhan/3138/view_cyuld_uzsen_2019.04.19

²⁴ О.Мөнхсайхан, Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг Засаг даргын үзэмжээр хааж, боож байна, /ярилцлага/, <https://ikon.mn/n/z1y>

дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” хэмээн хэт өргөн хүрээнд зааснаараа улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнуудад өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл болгон ашиглах, сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр шүүхэд дуудах асуудал гардаг.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Ингэснээр Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” хэмээн зааснаас үзвэл мэдэгдлийн тогтолцоо бус 1994 онд анх хууль батлагдахад тусгагдсан зөвшөөрлийн тогтолцоо одоо хүртэл хэрэгжиж байгаа нь практикт нийцэхгүй байдлыг үүсгээд байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

1. Мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах талаар тодорхой тусгасан заалт хуульд байхгүй байна. Эдгээрийг хуульчлаагүйн улмаас сэтгүүлчдэд дарамт шахалт, хавчлага учруулах явдал тохиолддог аж. Иймд мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах талаар хуульчлах;

2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэсэн заалтыг “байгууллага биш, гэм буруутай нь тогтоогдсон албан тушаалтан, субъект хүлээнэ” гэж өөрчлөх. Зохиогчийн өгсөн буюу сурвалжлагчийн нэртэй түгээж байгаа мэдээллээс бусад бүх мэдээллийн хариуцлагыг редакци хариуцах нь зүйтэй юм.

3. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан” гэх зохицуулалт ерөнхий байгаагаас үзэл бодлоо илэрхийлсний төлөө сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр шүүхэд дуудаж байгаа энэхүү гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтыг энэ хууль болон Эрүүгийн хуулиас хасах. Иргэний хуулиар зохицуулагдсан харилцааг давхардуулан зохицуулах шаардлагагүй юм.

4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь үндэсний хэмжээнд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах гол зохицуулалт бүхий хууль болохын хувьд сайжруулах шаардлагатай буюу бусад хуультай зөрчилдсөн байна. Тухайлбал: Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.”, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Хот сонин, радио, телевизтэй байж болно” гэж тус тус заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэсэн заалттай нийцээгүй байх тул дээрх заалтуудыг тус хуулиудаас хасах. Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэт ерөнхий зохицуулалттай тунхагийн шинжтэй хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсч байгаа тул цаашид нарийвчлан зохицуулах;

5. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” гэж заасныг “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

Олон улсын хэм хэмжээ, Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль /1992/
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1945/
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт түүний нэмэлт протокол, /1945 он/
- Хүний эрхийн хорооны үйл ажиллагааны түр журам /1978/
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ /1953/
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /1998/
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль /1994/
- Олон нийтийн радио, телевизийн тухай /2005/
- Мэдээллийн ил тод байдал, ба мэдээлэл авах эрхийн тухай /2011/
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай /2011/
- Эрүүгийн хууль /2002/
- Эрүүгийн хууль /2016/
- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /2016/
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /1994/
- Хүүхэд хамгааллын тухай хууль /2016/
- Зөрчлийн тухай хууль /2017/
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-н 2003 оны 41 дүгээр тогтоол.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай, УИХ-н 2004 оны 26 дугаар тогтоол.
- “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол;

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл II боть, 2010-2011
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь” Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он,
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Глоб Интернейшнл ТББ, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Сэтгүүлч ба хууль, №3, 2001 он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Хүний эрхийн цуврал нийтлэл”, 2012 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он.
- О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, №2, 2017 он.
- О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1, 2018 он.
- Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, №3, 2004 он.

Бусад эх сурвалж

- www.shuukh.mn, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан

- www.legalinfo.mn, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
- <https://rsf.org/en/ranking/2018>, Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагын цахим сан,
- www.nhrm.gov.mn, Монголын Хүний эрхийн үндэсний комисс цахим сан
- <http://www.globeinter.org.mn>, Глоб интернэшнл ТББ-ын цахим сан
- www.legaldata.mn, Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1	Авлигын эсрэг хууль	2006-07-06	5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.
2	Ард нийтийн санал асуулгын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2016-02-05	16.5.Санал асуулга явуулах ажиллагаанд ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.
3	Архивын тухай хууль	1998-01-02	25.3.Архивын баримтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр архив өөрөө санаачлан сурталчилж болно.
4	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/	2000-01-28	9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.
5	Ашигт малтмалын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2006-07-08	17.4.Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
6	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995-03-30	3/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.
7	Банкны тухай /шинэчилсэн найруулга/	2010-01-18	38.1.Банк нь энэ хуулийн 37.2-т заасан шаардлагыг хангасан улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлж байна.
8	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /шинэчилсэн найруулга/	2010-06-10	3.1.14.“албан ёсны тогтмол хэвлэл” гэж энэ хуульд заасан барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтийн хүртээл болгох зорилгоор Парисын конвенцийн 12.2-т заасны дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрхлэн гаргах хэвлэл болон вэб хуудас, цахим мэдээллийг;
9	Боловсролын тухай	2002-05-03	42.2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

10	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	2008-05-20	20.2.3.барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ.
11	Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/	2008-05-20	29.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх дор дурдсан бараанд гаалийн түргэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно: 29.1.5.сонин, тогтмол хэвлэл, мэдээллийн болон эрдэм шинжилгээ, судалгааны материал;
12	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2010-07-08	5.1.6.“албан хэргээр оршин суугч” гэж төрийн байгууллагын урилгаар болон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллахаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг;
13	Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/	2014-07-01	19.2.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
14	Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2015-07-02	7.3.Хэвлэл мэдээллийн байгууллага гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөг олон нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ.
15	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-02	10.5.Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.
16	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1997-12-05	11 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг
17	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/	2016-12-22	7.2.Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.
18	Гэрээт харуул хамгаалалтын тухай	2000-01-20	9.1.3.үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн тухай аливаа мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх;
19	Дайчилгааны тухай	1998-05-15	4.5.Улсын дайчилгаа явуулахад дараах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 4.5.8.хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах;

20	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	2011-02-02	18.3.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;
21	Залуучуудийн хөгжлийг дэмжих тухай	2017-05-08	8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;
22	Зар сурталчилгааны тухай	2002-05-30	3.1.1."зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;
23	Захиргааны ерөнхий хууль	2015-06-19	5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно: 5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;
24	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/	2017-05-11	5.12 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих 3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 5.18 дугаар зүйл.Онц байдлын тухай хууль зөрчих 3.Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын журам зөрчсөн, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих 1.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах замаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах зорилгоор улсын хилээр оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг

			<p>зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>5.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.5.Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>6.21 дүгээр зүйл.Гүтгэх</p> <p>1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>
25	Хог хаягдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2017-05-12	42.2.3.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаархи үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах;
26	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай	1993-12-20	<p>34 дүгээр зүйл. Хотын хэвлэл, мэдээлэл</p> <p>Хот сонин, сэтгүүл, радио, телевизтэй байж болно.</p>
27	Хөрөнгө оруулалтын тухай	2013-10-03	<p>21.1.Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна:</p> <p>21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо.</p>
28	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	10.1.Хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой бусад мэдээллийг нууцлах ба эдгээр мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараах, хохирогчийн нүүр царай, дуу хоолойг бусдад танигдахуйц байдлаар түгээхийг хориглоно.
29	Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос	2012-12-13	13.1.Хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцоно.

	сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/		
30	Хүүхэд хамгааллын тухай	2016-02-05	8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
31	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	1998-08-28	Бүхэлдээ
32	Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай /шинэчилсэн найруулга/	2010-05-27	27.1.Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг мэргэжлийн хэвлэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно. 27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараахь зүйлийг хориглоно: 27.4.1.эмийг импортлох, худалдах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
33	Монгол Улсын батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2016-09-01	15.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.
34	Монгол Улсын их хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2006-01-26	20.5. Төрийн байгуулалтын байнгын хороо: 20.5 8. хэвлэл мэдээллийн хараат бус байдал;
35	Монгол хэлний тухай	2015-02-12	19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ: 19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах; 19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх 19.1.3.хуульд заасан бусад үүрэг.
36	Нийтийн сонсголын тухай	2015-07-08	18.4.Нээлттэй сонсголд хэвлэл, мэдээллийн төлөөллийг заавал оролцуулна.
37	Нялх балчир хүүхдийн хүнсний тухай	2017-05-12	10.1.Доор дурдсан бүтээгдэхүүнийг сурталчлах, дэмжихийг хориглоно:

			10.1.2.эрүүл мэндийн болон хяналтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлсэн бүтээгдэхүүн.
38	Ойн тухай /шинэчилсэн найруулга/	2012-05-17	41.2.4.хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойн тухай мэдлэг, ойг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчлах.
39	Олон нийтийн радио, телевизийн тухай	2005-01-27	9.4.Олон нийтийн радио, телевиз хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана.
40	Патентийн тухай /шинэчилсэн найруулга/	2006-01-19	22.2.Төрийн нууцад хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг хэвлэлд нийтлэхгүй.
41	Садар самуун явдалтай тэмцэх тухай	1998-01-22	<p>5 дугаар зүйл.Садар самууныг сурталчлахыг хориглох</p> <p>5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.</p> <p>5.2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно.</p> <p>5.3.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.</p>
42	Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2014-05-15	49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.
43	Сонгуулийн тухай хууль	2015-12-25	<p>5.4.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.</p> <p>68.10.Энэ хуулийн 68.6, 68.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>68.11.Энэ хуулийн 68.6, 68.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.</p> <p>70.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p>

			<p>70.1.6.хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах;</p> <p>70.7.Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуульд оролцогч аль нэг талын талаар бүх төрлийн мэдээ, мэдээлэл гаргах, гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.</p>
44	Тамхины хяналтын тухай /шинэчилсэн найруулга/	2005-07-01	<p>8.1.Дараахь хэлбэрээр тамхи сурталчлахыг хориглоно:</p> <p>8.1.1.тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж, тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэллэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлах;</p>

Хавсралт 2

Хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг болгосон, үйл ажиллагааг нь хориглосон хууль

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1	Авлигын эсрэг хууль	2006-07-06	5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.
2	Архидан согтуурахтай тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/	2000-01-28	9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.
3	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-02	16.3.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1997-12-05	11 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг
5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	2016-12-22	7.2.Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

	/шинэчилсэн найруулга/		
6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2015-07-08	7.6.9.иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөгөө үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх, түгээхийг үүрэг болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
7	Монгол хэлний тухай хууль	2015-02-02	19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ: 19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах; 19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх; 19.1.3.хуульд заасан бусад үүрэг.
8	Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль	1998-01-22	5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.
9	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	8.1.Хэвлэл, мэдээллийн байгууллага дор дурдсан зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглоно: 8.1.1.хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаарх мэдээлэл; 8.1.2.гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа; 8.1.3.хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэхүйц бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашигласан ил буюу далд зар сурталчилгаа.
10	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай	1998-08-28	2 дугаар зүйл Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.
11	Эм, Эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль	2010-05-27	27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараахь зүйлийг хориглоно: 27.4.1.эмийг импортлох, худалдах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1.	Авлигын эсрэг хууль	2006-07-06	<p>28 дугаар зүйл. Улс төрийн баталгаа</p> <p>28.2. Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.</p>
2.	Боловсролын тухай	2006-07-06	<p>5 дугаар зүйл. Боловсролын үндсэн зарчим</p> <p>5.1. Боловсролын үндсэн зарчим нь:</p> <p>5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;</p> <p>44 дүгээр зүйл. Багшийн эрх, үүрэг</p> <p>44.2. Багш дараахь үүрэгтэй:</p> <p>44.2.6. суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;</p>
3.	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-02	<p>40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт</p> <p>40.4. Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>40.4.1. иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;</p>
4.	Гүйцэтгэх ажлын тухай	1997-12-19	<p>5 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл</p> <p>Хувь хүний иргэний харьяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын байдал нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад саад болохгүй.</p> <p>14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах</p> <p>14.1. Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн нь зөвшөөрснөөр иргэний харьяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал,</p>

			хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.
5.	Дайны байдлын тухай	1998-5-15	26 дугаар зүйл.Хүний эрх, эрх чөлөөний баталгаа 26.1.Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно.
6.	Донорын тухай /шинэчилсэн найруулга/	2018-1-19	12 дугаар зүйл.Донорт тавигдах шаардлага 12.1.Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын байна. 12.2.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
7.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай	1994-7-7	Бүхэлдээ
8.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	2011-2-2	5 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого 5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана: 5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;
9.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	2017-05-18	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.3.“залуучуудын оролцоо” гэж залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг; 5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим 5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална: 5.1.3.залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах.

10.	Зар сурталчилгааны тухай	2002-5-30	7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа 7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно: 7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан;
11.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/	2016-2-04	4 дүгээр зүйл. Шүүхийн өмнө эрх тэгш байх 4.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана
12.	Зөвлөлдөх санал асуулгын тухай	2017-02-09	5 дугаар зүйл. Зөвлөлдөх санал асуулгын зарчим 5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна: 5.1.1.хууль дээдлэх; 5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах; 5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;
13.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	2002-1-10	4 дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш байх 4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.
14.	Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай	1993-6-5	15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

15.	Монгол Улсын Үндсэн хууль	1992-01-13	<p>Арван дөрөвдүгээр зүйл.</p> <p>1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.</p> <p>2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.</p> <p>Арван зургадугаар зүйл.</p> <p>Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:</p> <p>10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;</p> <p>16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;</p> <p>Арван наймдугаар зүйл.</p> <p>4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.</p> <p>Арван есдүгээр зүйл.</p> <p>1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.</p> <p>2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.</p> <p>3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.</p>
-----	---------------------------	------------	---

16.	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай	2000-12-07	<p>3 дугаар зүйл. Комисс, түүний үйл ажиллагааны зарчим</p> <p>3.1. Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн.</p> <p>21 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа</p> <p>21.2. Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.</p>
17.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2016-1-07	<p>6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг</p> <p>6.1. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг тусалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.</p>
18.	Нийтийн сонсголын тухай	2015-07-08	<p>3 дугаар зүйл. Үндсэн зарчим</p> <p>3.1. Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх зарчмыг удирдлага болгоно</p>
19.	Олон нийтийн радио, телевизийн тухай	2005-1-27	<p>8 дугаар зүйл. Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого</p> <p>8.2. Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална:</p> <p>8.2.1. ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх;</p> <p>8.2.2. улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;</p>
20.	Онц байдлын тухай	1995-11-14	<p>17 дугаар зүйл. Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт</p> <p>1. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал,</p>

			хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
21.	Прокурорын тухай /шинэчилсэн найруулга/	2017-06-09	61 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа 61.1.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
22.	Сонгуулийн төв байгууллагын тухай	2006-01-12	11 дүгээр зүйл. Хорооны гишүүний бүрэн эрхийн баталгаа 11.11.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ хашиж буй төрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандана.
23.	Сонгуулийн тухай	2015-12-25	11 дүгээр зүйл.Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх 11.1.Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. 76 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны баталгаа 76.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь энэ хуульд тусгайлан зааснаас гадна доор дурдсан эрх эдэлнэ: 76.1.2.үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
24.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай	1999-7-1	5 дугаар зүйл.Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал 5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.
25.	Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/	2017-12-07	31 дүгээр зүйл.Хориглох зүйл 31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.
26.	Төрийн бус байгууллагын тухай	1997-1-31	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо

			<p>Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг;</p> <p>5 дугаар зүйл.Төрийн бус ба</p> <p>йгууллага байгуулах, оролцох эрх</p> <p>1.Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.</p>
27.	Улс төрийн намын тухай /шинэчилсэн найруулга/	2005-1-28	<p>4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт</p> <p>4.1.Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.</p> <p>18 дугаар зүйл.Гишүүний татвар, намд өгөх хандив</p> <p>18.2.Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Хандивыг зөвхөн тухайн шатны намын байгууллагын дансаар дамжуулж авна.</p>
28.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай	1998-01-02	<p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо</p> <p>3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>3.1.2."улс төрийн хэлмэгдүүлэлт" гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;</p>
29.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	2016-02-05	28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх

			28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.
30.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /шинэчилсэн найруулга/	2011-06-17	4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;
31.	Хөдөлмөрийн тухай	1999-05-14	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.14."албадан хөдөлмөр" гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг; 7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох 7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно. 7.4.Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.
32.	Хүүхдийн эрхийн тухай	2016-02-05	4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;

			<p>5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх</p> <p>5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй.</p> <p>6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх</p> <p>6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ:</p> <p>6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;</p>
33.	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай	1998-08-28	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.</p> <p>бүхэлдээ</p>
34.	Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-09	<p>22 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага</p> <p>22.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.</p> <p>84 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа</p> <p>84.3.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана.</p> <p>84.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.</p>
35.	Цэргийн албаны тухай	2016-09-01	<p>4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг</p> <p>4.2.Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.</p>

36.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай /шинэчилсэн найруулга/	2017-06-09	<p>7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага</p> <p>7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.</p>
37.	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/	2015-12-03	<p>1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим</p> <p>2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.</p> <p>1.4 дүгээр зүйл.Гэм буруугийн зарчим</p> <p>4.Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.</p> <p>10.1 дүгээр зүйл.Хүнийг алах</p> <p>2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.</p> <p>14.3 дугаар зүйл.Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах</p> <p>1.Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.</p> <p>19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах</p> <p>1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх</p>

			-Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.
38.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/	2017-05-18	1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

